



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 122

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 58,080,900.00 (тавин найман сая наян мянга есөн зуун) төгрөгийн балансын үнэ, 14,775,822.74 (арван дөрвөн сая долоон зуун далан таван мянга найман зуун хорин хоёр төгрөг далан дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн захирал Т.Хэрүүгад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг тус тус даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001671

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн
 АББ... Дугаар тогтоолын хавсралт



Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
 данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ашиглалтад орсон огноо	Балансын		Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
					нэг бүрийн үнэ	енг үнийн		
1	2 давхар модон барилга	ш	1	1/1/2005	58,080,900.00	58,080,900.00	14,775,822.74	43,305,077.26
	Нийт дүн		1			58,080,900.00	14,775,822.74	43,305,077.26
								(дөчин гурван сая гурван зуун таван мянга далан долоон төгрөг хорин зургаан мөнгө)
								(арван дөрвөн сая долоон зуун далан таван мянга найман зуун хорин хоёр төгрөг далан дөрвөн мөнгө)